



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/21

Мөрөн сум

Салбар комисс шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, Монгол Улсын Засгийн 2021 оны 173 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын дүрмийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Комиссын дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Боловсрол, шинжлэх ухааны газрын Насан туршийн боловсролын мэргэжилтэн

Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн их эмч

Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн мэдрэлийн их эмч

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны Хөвсгөл аймаг дахь салбарын зохицуулагч

Нарийн бичгийн дарга: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн Хүүхдийн нийгмийн ажилтан

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, салбар дундын оролцоог сайжруулах ажлыг ерөнхий удирдлагаар хангаж ажиллахыг салбар комисст үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/168 дугаар захирамжийг хүчингүйд тооцугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712010073